



Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх  
Статистикийн хэлтэс

# ХҮН АМЫН АМЬДАРЧ БУЙ ОРЧИН, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТ



Арвайхээр хот  
2019 он

## Агуулга



АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....2



ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ.....3



АХУЙН НӨХЦӨЛ.....4



СУРАЛЦАХ НӨХЦӨЛ.....5



ЭРҮҮЛ АМЬДРАХ ОРЧИН.....6-7



АЮУЛГҮЙ БАЙДАЛ.....8-9



ХҮҮХЭД ГЭР БҮЛ.....10-11



## АЙМГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Өвөрхангай аймаг нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хувьд 19 сум, 111 баг, 115.7 мянган хүн ам, 33.1 мянган өрхтэй. Нийт хүн амын 31.3 хувийг 15 хүртэлх насны хүүхэд, 64.2 хувийг 15-64 насныхан, 4.5 хувийг 65-аас дээш насныхан эзэлж, 49.8 хувь нь эрэгтэй, 50.2 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийт өрхийн 27.9 хувь нь аймгийн төвд, 23.8 хувь нь сумын төвд, 48.3 хувь нь хөдөөд суурьшсан.

Өдгөө зах зээлийн нөхцөлд хөдөө аж ахуй, газар тариалан, жижиг дунд үйлдвэрлэл, барилга, барилгын материал, аялал жуулчлалын салбаруудыг хөгжүүлж, орон нутгийн хөгжил дэвшилд хувийн хэвшлийн оролцоо дийлэнх хувийг эзэлж, бүтээн байгуулалт, бизнесийн цар хүрээ өдрөөс өдөрт өргөжин тэлж байна. Хосгүй сайхан байгаль өнө мөнх дурсагдах уламжлалт ёс заншлаа сэргээн хайрлан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, айл хотол, ахан дүүсээрээ ажлын байр бий болгож, амьдрал ахуйгаа дэвжээж, их бүтээн байгуулалтын ажилд Өвөрхангайчууд шамдан ажиллаж байна.

Өвөрхангай аймаг нь Монгол улсын төв хэсэгт Архангай, Булган, Баянхонгор, Төв, Дундговь, Өмнөговь аймгуудтай хиллэдэг. Газар зүйн байрлалаар далайн түвшнээс 1813 метрт өргөгдсөн, 102 градус 47 минутын уртраг 46 градус 16 минутын өргөрөгт, хойноос урагшаа 385 км, зүүнээс баруун хил хүртэл 310 км үргэлжилнэ.

Аймгийн нутаг дэвсгэрийг газрын нэгдмэл сангийн ангиллаар авч үзэхэд 2019 онд нийт нутгийн 90.5 хувийг хөдөө аж ахуйн газар, 5.8 хувийг улсын тусгай хэрэгцээний газар, 2.4 хувийг ойн сан бүхий газар, 0.1 хувийг усан сан бүхий газар, 0.7 хувийг хот тосгон бусад суурин газар, 0.4 хувийг зам шугам сүлжээний газар эзэлж байна.



## ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ


Аймгийн нийт өрх 2020 оны Хүн ам, орон сууцны тооллогын үр дүнгээр 33062 болсон байна. Нийт өрхийн 27.9 хувь нь аймгийн төвд, 23.8 хувь нь сумын төвд, 48.3 хувь нь хөдөөд суурьшсан байна.

Сүүлийн жилүүдэд орон сууцны барилгууд нэмэгдэж 2010 оноос орон сууцанд амьдардаг өрхийн тоо нэмэгдэж байгаа хэдий ч нийт өрхийн 69.0 хувь нь гэрт оршин сууж байна.

Байршил	Үүнээс					
	Бие даасан тохилог сууц	Бусад сууц	Гэр	Нийтийн байр	Орон сууцны байшин	Сууцны тусдаа байшин
ӨВӨРХАНГАЙ	157	248	22 816	107	1 678	8 056

Нийт өрхийн 69.0 хувь нь гэрт, 24.4 хувь нь сууцны тусдаа байшинд, 5.1 хувь нь орон сууцны байшинд, 0.3 хувь нь нийтийн зориулалттай бусад сууцанд, 0.4 хувь нь бие даасан тохилог сууцанд тус тус амьдарч байна.

### Өрхийн тоо, сууцны төрлөөр





## АХУЙН НӨХЦӨЛ

ЦАХИЛГААНЫ ЭХ ҮҮСВЭР	2018	2019
Төвлөрсөн систем	18094	18878
Сэргээгдэх эрчим хүчний төхөөрөмж	14097	13013
Бага оврын цахилгаан үүсгүүр	1684	682
Дизель станц	45	6
Цахилгааны эх үүсвэргүй	732	235

УСАН ХАНГАМЖ	2018	2019
Бие даасан систем - халуун, хүйтэн устай	45	40
Бие даасан систем - хүйтэн	46	49
Зөөврийн	33065	30868
Төвлөрсөн усан хангамж - халуун, хүйтэн устай	971	1014
Төвлөрсөн усан хангамж - хүйтэн устай	525	843

ХАЛААЛТЫН ЭХ ҮҮСВЭР	2018	2019
Ердийн галлагаа	32505	29849
Нам даралтын зуух	348	875
Төвлөрсөн систем	1671	1993
Цахилгаан халаагуур	128	97



## СУРАЛЦАХ НӨХЦӨЛ

Ерөнхий боловсролын сургууль 2008-2009 оны хичээлийн жилээс 12 жилийн тогтолцоонд шилжиж, 6 настай хүүхдийг нэгдүгээр ангид элсүүлэх болсноор 5 хүртэлх насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж байна.

2019-2020 онд нийт 42 цэцэрлэгийн 255 бүлэгт 6630 хүүхэд хүмүүжиж байгаа нь өмнөх оныхоос 268 хүүхдээр буюу 3.9 хувиар буурсан байна.

2018-2019 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 31 сургуулийн 799 бүлэгт 21566 хүүхэд өдрөөр суралцаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн багшийн тоо 1122 байгаагийн 34.9 хувь нь бага ангийн, 40.2 хувь нь дунд ангийн, 24.9 хувь нь ахлах ангийн багш байна.

Сумдын нэр	Ерөнхий боловсролын сургууль			Цэцэрлэг		
	ЕБС-н тоо	Бүлгийн тоо	Багш нарын тоо	Цэцэрлэгийн тоо	Бүлгийн тоо	Үндсэн багшийн тоо
<b>БҮГД</b>	<b>31</b>	<b>799</b>	<b>1122</b>	<b>42</b>	<b>255</b>	<b>194</b>
Баян-Өндөр	1	25	32	1	7	6
Бүрд	1	13	21	1	6	1
Бат-Өлзий	1	61	68	2	17	15
Баруунбаян-Улаан	1	21	28	1	6	4
Баянгол	1	20	29	1	8	6
Гучин-Ус	1	16	25	1	8	5
Есөнзүйл	1	20	23	1	6	3
Өлзийт	1	12	19	1	4	2
Зүүнбаян-Улаан	1	16	23	1	6	4
Богд	1	38	44	1	5	4
Нарийнтээл	2	26	32	2	10	6
Сант	1	24	32	1	9	4
Тарагт	2	16	22	1	5	4
Төгрөг	1	21	27	1	8	5
Уянга	3	78	106	2	13	9
Хайрхандулаан	1	19	27	1	4	3
Хужирт	1	48	63	2	18	12
Хархорин	4	96	146	6	30	25
Арвайхээр	6	229	355	15	85	76




## ЭРҮҮЛ АМЬДРАХ ОРЧИН

2019 онд 2586 эх амаржиж 2605 хүүхэд төрсөн нь өмнөх оноос 202 хүүхдээр буюу 8.4 хувиар өсчээ. Эмнэлэгт 587 хүн нас барсны 6.5 хувийг 1 хүртлэх насны хүүхэд, 1.4 хувийг 1-5 хүртэл насны хүүхэд эзэлж байна.

Нэг хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоо 2019 онд 38 болж 2018 оныхоос 2 хүүхдээр буюу 5.5 хувиар өсч, 1-5 хүртлэх насандаа эндсэн хүүхэд 2 хүүхдээр буюу 20.0 хувиар буурсан байна.


### Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд



2019 онд халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 894 бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 119 хүнээр буюу 11.8 хувиар буурсан байна. Нийт өвчлөлийн 14.3 хувь нь салхин цэцэг, 33.2 хувийг тэмбүү, 11.0 хувийг цусан суулга, 11.0 хувийг трихоминиаз, 13.6 хувийг заг хүйтэн, 6.5 хувийг сүрьеэ, 0.9 хувийг вируст гепатит эзэлж байна.

Халдварт өвчлөлийг өмнөх оныхтой харьцуулбал салхин цэцэг 30.8 хувиар, цусан суулга 2.1 дахин буурч, трихоминиаз 12.6 хувиар, тэмбүү 60.5 хувиар, сүрьеэ 45.0 хувиар, вируст гепатит 33.3 хувиар, заг хүйтэн 8.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

## Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо



## ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, сумдаар

Сумд	Халдварт өвчнөөр өвчлөгчид		Үүнээс:								
			Вирус гепатит	Цусан суулга	Бруцеллэз	Заг хүйтэн	Тэмбүү	Трихоминиаз	Сүрьеэ	Салхинцэцэг	Бусад
	2018	2019									
Баруунбаян-Улаан	7	5		1		2	1		1		
Бат-Өлзий	20	9					4	4	1		
Баянгол	16	17				6	1	2	4	2	2
Баян-Өндөр	14	6			2	1	2		1		
Богд	14	20	2			3	9	4	2		
Бүрд	3	3					1		1		1
Гучин-Ус	9	2					2				
Есөнзүйл	14	4				1		1	1		1
Зүүнбаян-Улаан	17	28		2		3	10	6		2	5
Нарийнтээл	13	2					1	1			
Өлзийт	13	3					1			2	
Сант	4	11				6	1	1	1	1	1
Тарагт	26	12		1		3		4	1	3	
Төгрөг	8	16		1			5	6	2		2
Уянга	34	53		6		3	28	9	7		
Хайрхандулаан	12	19		3		7	4	1	1		3
Хархорин	78	145	1		1	18	94	11	4	11	5
Хужирт	59	42				3	15	18	2	3	1
Арвайхээр	652	497	5	84	2	66	118	30	29	104	59
<b>Дүн</b>	<b>1013</b>	<b>894</b>	<b>8</b>	<b>98</b>	<b>5</b>	<b>122</b>	<b>297</b>	<b>98</b>	<b>58</b>	<b>128</b>	<b>80</b>



## АЮУЛГҮЙ БАЙДАЛ

2019 онд аймгийн хэмжээнд 613 гэмт хэрэг гарсан нь өмнөх оныхоос 57 гэмт хэргээр буюу 8.5 хувиар буурсан байна. Энэ онд гарсан гэмт хэргийн 298 нь буюу 48.6 хувь нь аймгийн төвд үйлдэгджээ.

Нийт гэмт хэргийн дотор өндөр хувийн жин эзэлдэг хэргүүдийг авч үзвэл: Хулгайн хэрэг 2019 онд 253 гарсан нь нийт хэргийн 41.3 хувийг эзэлж, өмнөх оныхоос 5 хэргээр буюу 1.9 хувиар буурсан байна. Хулгайн хэрэг дотроо хувийн өмчийн хулгай энэ онд 175 гарсан нь өмнөх оныхоос 1.1 хувиар, малын хулгай 54.0 хувиар өсч, авто тээврийн хэрэгслийн хулгай 27 хэргээр буюу 2.3 дахин буурсан байна. Бусдын бие махбодид гэмтэл учруулсан хэрэг энэ онд 180 гарсан нь нийт хэргийн 29.4 хувийг эзэлж байна.

2019 онд гарсан гэмт хэргийг 421 хүн үйлдсэний 11 хүн буюу 2.6 хувь нь хүүхэд, 262 хүн буюу 62.2 хувь нь 18-34 насны залуучууд, 139 хүн буюу 22.7 хувь нь 35-аас дээш насныхан үйлджээ. Мөн нийгмийн байдлаар нь авч үзвэл: Хамгийн өндөр буюу 45.6 хувийг ажилгүй иргэд, 29.9 хувийг малчин иргэд, 10.7 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, 4.3 хувийг оюутан сурагч, 7.4 хувийг албан хаагч үйлдсэн байна. Нийт хэрэг үйлдэгчдийн 203 хүн буюу 48.2 хувь нь согтуудаа үйлдсэн байна.

Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 1060.2 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оныхоос 122.6 сая төгрөг буюу 10.4 хувиар буурсан байна. Нийт учирсан хохирлын 251.3 сая төгрөг буюу 23.7 хувийг нөхөн төлүүлжээ. Гэмт хэргийн улмаас 208 хүн гэмтэж, 21 хүн нас барсан нь өмнөх оныхоос гэмтсэн хүний тоо 17.8 хувиар, нас барсан хүний тоо 40.0 хувиар тус тус буурчээ.

Гэмт хэргийн төрөл	2018	2019	Харьцуулалт 2019/2018	
			тоо	хувиар
Үйлдэгдсэн бүх хэрэг	670	613	-57	91.5
Бусдыг санаатай болон болгоомжгүй алах	4	4	-	100.0
Бусдыг хүчиндэх	16	27	11	168.7
Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	4	11	7	2.7 дах
ББМГУ гэмт хэрэг	233	180	-53	77.3
Хулгай:	258	253	-5	98.1
үүнээс: Малын	37	57	20	154.0
Хувийн өмчийн	173	175	2	101.2
Авто тээврийн хэргслийн	48	21	-27	2.2 дах
ХАБЭ гэмт хэрэг	50	27	-23	54.0
Албан тушаалын хэрэг				
Бусад хэрэг	105	111	6	105.7

## ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГЧДИЙН ТОО

	2018	2019	Харьцуулалт 2019/2018	
			тоо	хувиар
Хэрэг үйлдэгчид бүгд	492	421	-71	85.6
Үүнээс : Хүүхэд оролцсон	17	11	-6	64.7
18-34 насны	277	262	-15	94.6
35-аас дээш	191	139	-52	72.8
Нийгмийн байдлаар:				
Албан хаагч	39	31	-8	79.5
Малчин	129	126	-3	97.7
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	85	45	-40	52.9
Ажилгүй	212	192	-20	90.6
Оюутан, сурагч	22	18	-4	81.8
Бусад	5	9	4	180.0
Бүлэглэн үйлдсэн	110	127	17	115.4
Согтуугаар	189	203	14	107.4
Албадан саатуулагдсан	1499	1157	-342	77.2
Баривчлагдсан	981	1286	305	131.1
Авто машин жолоодох эрх хасагдсан жолооч	921	1074	153	116.6

## ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ

	2018	2019	Харьцуулалт 2019/2018	
			тоо	хувиар
Гэмт хэргийн улмаас нас барсан хүн	35	21	-14	60.0
Гэмт явдлын улмаас гэмтсэн хүн	253	208	-45	82.2
Нийт хохирол /сая.төг/	1182.8	1060.2	-122.6	89.6
Үүнээс: Нөхөн төлүүлсэн	435.3	251.3	-184.0	57.7




## ХҮҮХЭД ГЭР БҮЛ

Аймгийн хэмжээгээр 2019 онд өнчин хүүхдийн тоо 1610 болж, нийт хүүхдийн 4.5 хувийг эзэлж байна. Нийт өнчин хүүхдийн 5.5 хувь буюу 89 хүүхэд нь бүтэн өнчин, 94.5 хувь буюу 1521 нь хагас өнчин хүүхдүүд байна. Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар өрх толгойлсон эмэгтэй 3813 байгаа нь өмнөх оны мөн үеэс 8.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

## БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО


	2016		2017		2018		2019	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
<b>Бүтэн өнчин хүүхдийн тоо</b>	<b>108</b>	<b>64</b>	<b>105</b>	<b>53</b>	<b>102</b>	<b>47</b>	<b>89</b>	<b>40</b>



## ХАГАС ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО


	2016		2017		2018		2019	
	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй	Бүгд	Эмэгтэй
<b>Хагас өнчин хүүхдийн тоо</b>	<b>1638</b>	<b>783</b>	<b>1668</b>	<b>813</b>	<b>1520</b>	<b>753</b>	<b>1521</b>	<b>710</b>

Хагас өнчин хүүхдийн тоо, 2015-2019 оноор



БҮРТГҮҮЛСЭН ГЭРЛЭЛТ, ЦУЦЛАЛТ, ҮРЧЛЭЛТ

	Гэрлэлт		Цуцлалт		Үрчлэлт	
	2018	2019	2018	2019	2018	2019
БҮГД	561	545	78	75	58	75



**Ашигласан материал, номзүй:**

1. Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын үр дүн
2. Аймгийн 2019 оны жилийн эцсийн нийгэм, эдийн засгийн танилцуулга
3. [www.1212.mn](http://www.1212.mn)
4. [www.uvurkhangai.nso.mn](http://www.uvurkhangai.nso.mn)

**СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХЭРХЭН АВАХ ВЭ?**

Цахимгаар: [www.1212.mn](http://www.1212.mn)  
Статистик мэдээллийн нэгдсэн сан

[www.nso.mn](http://www.nso.mn)  
Тусгай зориулалтын байр / Энгийн өрийн өсөлтийн үзүүлэлт / Энгийн өрийн өсөлтийн үзүүлэлт / Энгийн өрийн өсөлтийн үзүүлэлт

SOCIAL NETWORK  
www.facebook.com/Statistic-Mongolia  
www.youtube.com/statistic\_mn

Утсаар: 1900-1212  
Лавлах утас

Учирлаг гар утас, таблет ашиглан статистикийн мэдээлэл авах 1212.mn аппликейшн

uvurkhangai.nso.mn  
Өвөрхангай аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтэс

@stat\_uvurkhangai  
Нутгийн удирдлагын ордон 403, 417 тоот

70322427, 70323442  
uvurkhangai@nso.mn

**СТАТИСТИК - ХӨГЖИЛД ХӨТЛӨГЧ ХҮЧ**

ХЯНАСАН: ХЭЛТСИЙН ДАРГА О. ТҮМЭНЖАРГАЛ

ТАНИЛЦУУЛГА БЭЛТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН Э.ӨҮЛЭН